“ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨХХК

“ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨХХК-ИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2025 ОН

АГУУЛГА

- Компанийн үндсэн зорилго
- Үйл ажиллагааны стратегийн зорилтууд
- Үндсэн чиглэлийн үйл ажиллагаа
- Орлого нэмэгдүүлэх, зардал хэмнэх бууруулах чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагаа
- Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт
- Бүтээн байгуулалтын ажлууд
- Гадаад хамтын ажиллагааг хэрхэн өргөжүүлсэн
- Дээд шатны байгууллагуудаас өгсөн үүрэг чиглэл, зөвлөмжийн хэрэгжилт
- Ажилчдын нийгмийн баталгааг ханган ажилласан тухай

КОМПАНИЙН ҮНДСЭН ЗОРИЛГО

Монгол Улсын нутаг дэвсгэрт болон агаарын зайд нислэгийн аюулгүй байдлыг хангасан, хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, аюулгүй, үр ашигтай, тогтвортой, хүртээмжтэй орчин үеийн дэвшилтэт технологид суурилсан нисэхийн ба нисэхийн бус үйлчилгээ эрхлэгч олон улсад тэргүүлэгч байгууллага байна.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИЙН ЗОРИЛТУУД

1. Нисэхийн аюулгүй байдлыг хангах, чанарын удирдлагын нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх
2. Агаарын навигацийн үйлчилгээ, нисэх буудлын үйлчилгээ, нисэхийн аюулгүй хамгаалалтын үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах
3. Удирдлага зохион байгуулалтаар хангах, байгууллагын дотоод үйл ажиллагааг зохион байгуулах, төлөвлөлт, гүйцэтгэлийг хангуулах, албан хэрэг хөтлөлтийг холбогдох хууль тогтоомж, стандартын дагуу хөтлөн явуулах, гадаад, дотоод хамтын ажиллагааг өргөжүүлэх, салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох
4. Хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, байгууллагын “Хүн төвтэй хөгжлийн бодлого” хэрэгжүүлэх, хүний нөөцийг бэлтгэх, мэргэшүүлэх, бүтээмжийг сайжруулах, ажилтан руу чиглэсэн хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх, ажилтны эрүүл мэндийг сахин хамгаалах, биеийн тамираар хичээллэх боломжоор хангах
5. Санхүү, эдийн засаг, төлөвлөлтийн үйл ажиллагааг нэгдсэн бодлого, чиглэл, удирдлагаар хангаж, орлогыг нэмэгдүүлэх, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах, хөрөнгийн үр ашгийг нэмэгдүүлэх, төсвийн гүйцэтгэлийн хяналтыг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалтыг оновчтой төлөвлөх, гүйцэтгэлийг хангах, худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах
6. Байгууллагын хөгжлийн бодлого, түүнд чиглэсэн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, байгууллагын орлогыг нэмэгдүүлэх, шинэ орлогын эх үүсвэр, бизнесийг хөгжүүлэх, судалгаа шинжилгээ хийх, барилга, байгууламжуудын бүртгэл, судалгааг хөтөлж, ашиглалтын байдалд хяналт тавих
7. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчныг сайжруулах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх, хэрэгжилт, үр дүнд хяналт тавих
8. Иргэний нисэхийн чиглэлээр олон улсад хэрэгжиж буй дэвшилтэт техник, технологи, инновацыг судалж үйл ажиллагаанд нэвтрүүлэх, мэдээлэл, техник технологийн системийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, оролцогч талуудын харилцан үр ашигтай, бүтээлч хамтын ажиллагааг хөгжүүлэх

“Иргэний нисэхийн үндэсний төв” ТӨХХК-ийн бүтэц, зохион байгуулалт

Монгол Улсын Засгийн газрын 2025.03.06-ны өдрийн “Үл хөдлөх хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай” 116 дугаар тогтоол, Засгийн газрын 2025 оны 11 дүгээр хуралдааны тэмдэглэлээс гарсан шийдвэрийн дагуу тус компанийн харьяанд үйл ажиллагаагаа явуулж байсан Шатахуун хангалтын албаны барилга байгууламж, газар, автомашин, тоног төхөөрөмж болон ажилтнуудыг “Эрчис ойл” ТӨХХК-д шилжүүлсэнтэй холбогдуулан тус компанийн ТУЗ-ийн 2025.05.29-ний өдрийн 04/25 дугаар тогтоолоор зохион байгуулалтын бүтэц шинэчлэн батлагдсан. Үүний дагуу тус компани нь дотоод бүтцийн нийт 21 нэгжтэй, 16 салбар нэгжтэй, орон нутгийн 20 нисэх буудалтай, нийт 2078 орон тоотой үйл ажиллагаагаа явуулж байна.

"Иргэний нисэхийн үндэсний төв" ТӨХХК-
ийн Телеелен удирдах зөвлөлийн 2025
оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 01/05
дугаар тогтоолын хавсралт



Иргэний нисэхийн дүрмээр гэрчилгээжсэн үйлчилгээнд аюулгүй байдал, чанарын удирдлагын тогтолцоог үр нөлөөтэйгөөр хэрэгжүүлж сайжруулах чиглэлээр

ТӨХХК болох үеийн эрсдэлийн үнэлгээг боловсруулах.

Монгол Улсын Зам, Тээврийн сайдын 2024.12.27-ны өдрийн А/290 дугаар тушаалаар "Иргэний нисэхийн үндэсний төв" ТӨХХК (цаашид компани гэх)-ийн дүрэм, зохион байгуулалтын бүтцийг тус тус баталсантай холбоотой байгууллагын үйл ажиллагаа, Монгол Улсын хууль тогтоомж болон ИНД-ийн хүрээнд эрхлэн явуулах үйлчилгээний аюулгүй байдлын эрсдэлийн түвшинд нөлөөлж болох өөрчлөлтийг таньж тогтоох, тухайн өөрчлөлтөөс үүдэн гарч болох аюулгүй байдлын эрсдэлийг тогтоох зэрэг үйл ажиллагаанд аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг 2025 оны 01 дүгээр сард хийж гүйцэтгэн тайланг гаргасан.

Эрсдэлийн үнэлгээнд суурилсан шилжилтийн үеийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтийг хангуулах.

Эрсдэлийн үнэлгээгээр Ноцтой-1, Дунд-24, Ердийн-1 эрсдэлүүд гарсан ба эрсдэлийн үнэлгээнд үндэслэн эрсдэлийг бууруулах зорилгоор ИНЕГ-ын харьяа Иргэний нисэхийн үндэсний төвийг "Иргэний нисэхийн үндэсний төв" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн бүтцэд шилжүүлэх шилжилтийн үеийн төлөвлөгөөг боловсруулсан. Тус төлөвлөгөөг батлуулахаар эрсдэлийн үнэлгээний тайлангийн хамт ИНЕГ-т 2025.01.09-ний өдрийн 01/07 тоот албан бичгээр хүргүүлж, 2025.01.22-ны өдөр ИНЕГ-ын даргаар батлуулан, хэрэгжилтийг хангасан.

"Иргэний нисэхийн үндэсний төв"-ийг төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн бүтцэд шилжүүлэх шилжилтийн үеийн төлөвлөгөөний хэрэгжилт:

Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	100%	90%	70%	50%	30%	0%	ХБ	Үнэлгээний хувь
8	51	43	1	3	3	-	-	1	95%

70%-ийн хэрэгжилттэй 3 арга хэмжээ байна.

1. "ИНҮТ" ТӨХХК-аас байгуулах хамтран ажиллах гэрээ, харилцан ажиллагааны зохицуулалтын журмыг шинэчлэн боловсруулах, батлуулах.
2. Үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой хөрөнгө, холбогдох баримтыг балансаас балансад шилжүүлэх шийдвэрийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраар гаргуулах.
3. "ИНҮТ" ТӨХХК-ийн салбар нэгжүүд бүтэц, зохион байгуулалт, технологийн баримт бичгүүдэд орсон өөрчлөлттэй уялдуулан хамтын ажиллагааны гэрээ, харилцан ажиллагааны зохицуулалтын журмуудад холбогдох өөрчлөлтийг шуурхай хийж, ажилтнуудад танилцуулах, үйл ажиллагаанд мөрдөх.

50%-ийн хэрэгжилттэй 3 арга хэмжээ байна.

1. "ИНҮТ" ТӨХХК-ийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримт боловсруулж, батлуулж мөрдөх.
2. "ИНҮТ" ТӨХХК-ийн санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой холбогдох эрх зүйн баримт бичгийг боловсруулж, батлуулах.

3. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд зааснаар "ИНҮТ" ТӨХХК-ийн мөрдөх Санхүүгийн тайлагналын олон улсын стандартыг тодорхой болгох.

Хүгацаа болоогүй хэрэгжилттэй 1 арга хэмжээ байна.

1. "Аюулгүй байдал, чанарын удирдлагын нэгдсэн тогтолцоог хэрэгжүүлэх төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг хангуулах, хэрэгжилтэд хяналт тавих.

2025 оны дотоод аудитын хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжилтийг хангах.

ИНҮТ-ийг "ИНҮТ" ТӨХХК болсонтой холбоотой 2025 оны дотоод аудитын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, 2025.04.18-ны өдрөөс үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Тус хөтөлбөрөөр батлагдсан дотоод аудитын хуваарийн дагуу 6 газарт дотоод аудит хийснээр нийт 8 үл тохирол, 43 зөвлөмжийг гарган холбогдох газруудад хүргүүлж хэрэгжилтийг хангуулж ажилласан.

Аюулгүй байдлын чанарын удирдлагын нэгдсэн тогтолцооны зааврын дагуу аюулгүй байдлын өгөгдлийн нэгдсэн санг үүсгэн, байнгын хяналтын тогтолцоог үйл ажиллагаанд бий болгох.

Аюулгүй байдал, чанарын удирдлагын нэгдсэн тогтолцооны зааврын дагуу аюулгүй байдлын өгөгдлийн 4 төрлийн сангийн бүтэц, схемийг боловсруулсан. Sqmd google drive үүсгэн өгөгдөл мэдээллийг бүртгэн ажиллаж байна. Нийт 46 салбар, нэгжүүдийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ үнэлгээг тус тус аюулгүй байдлын мэдээлэл болон бусад өгөгдлийг өгөгдлийн санд бүртгэн цахимжуулсан.

"ИНҮТ" ТӨХХК-ийн аюулгүй байдлын мэдээллийн санд бүртгэгдсэн мэдээллүүдийн аюул эрсдэлийн түвшнийг үнэлэн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг хийх үйл явцыг АБЧУГ-ын зүгээс 2025 оны эхний хагас жилийн байдлаар нийт 5 эрсдэлийн үнэлгээг хийж, холбогдох газруудад хүргүүлэн, аюул эрсдэлийг бууруулах арга хэмжээнд хяналт тавин ажиллаж байна.

"Аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо" дүрмийн хүрээнд аюулгүй байдал, чанарын нэгдсэн удирдлагын тогтолцоог хэрэгжүүлж, ИНД-ээр гэрчилгээжсэн аэродром, нисэх буудал, агаарын навигацийн үйлчилгээний байгууллагын үйл ажиллагааны аюулгүй байдлын гүйцэтгэлийг баталгаажуулахаар хяналт, шалгалтын үйл ажиллагааг тогтмол гүйцэтгэсэн. "Аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх төлөвлөгөө"-г 2025.03.21-ний өдөр батлан түүний хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

"ИНҮТ" ТӨХХК ИНД-171, ИНД-172, ИНД-173, ИНД-175, ИНД-139 дүрмүүдээр гэрчилгээжих.

ИНД-171, 172, 173, 175, 139 дүрмүүдийн шаардлагын дагуу Агаарын навигацийн үйлчилгээний техникийн байгууллагын ерөнхий заавар, Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллагын ерөнхий заавар, Нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллагын ерөнхий заавар, Нислэгийн журмын үйлчилгээний байгууллагын ерөнхий журмуудыг шинэчлэн боловсруулж, 01-1/238 тоот албан бичгээр ИНЕГ-т хүргүүлснээр үйл ажиллагаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

ИНД-173 дүрмийн хүрээнд Хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээний байгууллагын гэрчилгээгээс сунгуулах хүсэлтийг холбогдох материалын хамт 2025.04.14-ний өдрийн 01-1/421 дугаар албан бичгээр ИНЕГ-т хүргүүлэн, 2025.04.21-ний өдрийн АХУ-23/25 дугаартай удирдамжийн дагуу 2025.05.05-ны өдрөөс 2025.05.14-ний өдрүүдэд аудит шалгалтад хамрагдан гэрчилгээг сунгуулсан.

ИНД-171 дүрмийн хүрээнд Агаарын навигацийн үйлчилгээний техникийн байгууллагын гэрчилгээжих, ИНД-172 дүрмийн хүрээнд Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллагын

гэрчилгээжих, ИНД-175 дүрмийн хүрээнд Нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллагын гэрчилгээжих шалгалтад хамрагдаж 2025.04.07-ны өдөр тус тус гэрчилгээжсэн байна.

ИНД-139 дүрмээр гэрчилгээжих ажлын хүрээнд үйл ажиллагааны ерөнхий зааврын төслийг хянаж, нэмэлт өөрчлөлтүүдийг оруулан 2025.03.13-ны өдрийн 01-1/250 дугаартай албан бичгээр ИНЕГ-т хүргүүлэн хянуулж, байцаагчийн өгсөн зөвлөмжийн дагуу дахин өөрчлөлт оруулан, 2025.06.02-ны өдөр 01-1/750 дугаартай албан бичгээр гэрчилгээжүүлэх хүсэлтийг ИНЕГ-т хүргүүлсний дагуу НААХЗА-аас үзлэг шалгалтыг 2025.06.10-ны өдрөөс эхлэн хийж байна.

Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгасан дүгнэлтийг үндэслэн цаашид осол зөрчил давтагдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах.

АХОЗШША-ны аюулгүй ажиллагааны зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийг АХОЗШША-аас үнэлэн Нисэх буудлын үйлчилгээний чиглэлээрх 8 зөвлөмж тус бүр 100%-ийн хэрэгжилттэй, Агаарын навигацийн үйлчилгээний чиглэлээрх 3 зөвлөмж тус бүр 30%-ийн хэрэгжилттэй үнэлэгдсэн тайланг ЗТЯ-наас 2024.06.25-ны өдрийн 05/2782 дугаартай албан бичгээр 2024 онд ирүүлж байсан. Тус хэрэгжилт дутуу зөвлөмжүүдийн хэрэгжүүлж буй арга хэмжээ, гүйцэтгэлд хяналт хийсэн ИНЕГ-ын байцаагчийн 2025.06.18-ны өдрийн НТ-29/25 дугаартай нэгдсэн тайлан 2025 оны 6-р сард ирүүлсэн ба үүний дагуу үнэлэхэд агаарын навигацийн үйлчилгээний чиглэлээрх 1 зөвлөмж 100% болж, 2 зөвлөмж 30%, 70%-тай хэрэгжиж байна. /Хэрэгжилт 91%/

Удаашралттай буюу 30%-ийн хэрэгжилттэй 1 зөвлөмж байна.

1. Зөвлөмж 202101/02. ИНЕГ-т. Монгол Улсын агаарын зайд нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний аюулгүй ажиллагааг найдвартай түвшинд хангахын тулд бие даасан нөөц нислэгийн хөдөлгөөний ажиглалтын удирдлагын автоматжуулсан системийг бүрдүүлэх.

70%-ийн хэрэгжилттэй 1 зөвлөмж байна.

1. Зөвлөмж 202101/04. ИНЕГ-т. Нислэгийн хөдөлгөөний удирдлагын дадлагажуур (Бүс, Ойртолт, Аэродром)-ыг Нислэгийн удирдагчийн ажлын байрны тоног төхөөрөмжтэй ижил түвшинд, шаардлага хангасан хэмжээнд тоноглож үйл ажиллагаандаа ашиглах.

Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-ын стандарт, шаардлагад нийцүүлэн агаарын навигацийн үйлчилгээний аюулгүй, үр ашигтай, хүртээмжтэй байдлыг хангах чиглэлээр

Аэродром, ойртолтын нислэгийн хөдөлгөөний удирдлагын дадлагажуурыг шинэчилж, олон улсын стандарт шаардлагад нийцсэн сургалтын танхим байгуулах.

Иргэний нисэхийн ерөнхий газар болон "АЧСВС" ХХК хооронд байгуулсан "Аэродром, бүсийн ажиглалтын нислэгийн хөдөлгөөний удирдлагын дадлагажуурыг шинэчлэх" ИНЕГ/ХО/20240102023 дугаартай гэрээний дагуу нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийг Нислэгийн хөдөлгөөний удирдлагын дадлагажуурын байранд шинээр суурилуулах ажлыг гүйцэтгэх инженерийн баг, хяналтын инженерийг томилох тушаалын төслийг боловсруулан батлуулсан. Аэродром, бүсийн ажиглалтын нислэгийн хөдөлгөөний удирдлагын дадлагажуурын суурилуулалтын ажлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу 2025.03.27-2025.04.25-ны өдрүүдэд амжилттай гүйцэтгэн хэрэгжилтийг ханган ажилласан.

Автомат хамааралтай ажиглалтын системийн (ADS-B) газрын станцыг өргөтгөх. /2 байршилд/

Бүгд Найрамдах Итали Улсад үйлдвэр дээрх хүлээн авах тестийн сургалтад 5 ажилтан, үйлдвэр дээрх инженер техникийн ажилтнуудын сургалтад Нисэхийн холбоо, навигаци ажиглалтын албаны 8 инженер, техникийн ажилтныг 2025.03.26-ны өдрийн А/145 дугаар тушаалаар амжилттай хамруулсан.

Үйлдвэрлэгчээс тоног төхөөрөмжүүд ачигдсан бөгөөд бараа хүлээж авах комисс 2025.06.09-ний өдөр А/347 дугаар тушаалаар батлагдан. Мөрөн нисэх буудал, Сайхандулаанын ажиглалтын байгууламжид угсрах бэлтгэл ажил хангагдаж байна.

Нислэгийн хөдөлгөөний ажиглалтын удирдлагын үйлчилгээний зайчлалыг Олон улсын стандарт, ажиглалтын системүүдэд суурилсан минимум 5 NM хэвтээ зайчлалд нийцүүлэх ажлыг ИНЕГ-ын Нисэхийн аюулгүй ажиллагаа, хяналт зохицуулалтын албанд хянуулахаар хүргүүлэх.

АХОЗШША-ны 202101/03 дугаартай "Ойртолтын удирдлагын ажиглалт (terminal radar)-ын зориулалтын системийг бүрдүүлэх, үйл ажиллагаанд нэвтрүүлэх" аюулгүйн зөвлөмжийн дагуу Мөнх-Өлзийтэд байрлах радиолокаторыг Улаанбаатар ойртолтын үйл ажиллагаанд үргэлжлүүлэн ашиглахтай холбоотой судалгаа болон эрсдлийн үнэлгээг хийж, холбогдох баримтын хамт 2025.05.15-ны өдөр ИНЕГ-т хүргүүлсэн. Энэ ажлын хүрээнд 35/25 дугаартай удирдамжийн дагуу ИНЕГ-ын байцаагч нар аудит шалгалтыг 2025.06.09-06.13-ны өдрүүдийн хооронд хийгдэхээр төлөвлөсөн байна.

Бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын үйлчилгээнд динамик стрипик аргачлалыг нэвтрүүлэх.

Бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын үйлчилгээнд динамик стрипийг ашиглахтай холбоотой судалгааны ажлыг хийж, баримт бичгийн боловсруулалт бүрэн хийгдсэн. Үйлдвэрлэлийн туршилтын ажил хийгдэн судалгааны тайланг ИНЕГ-т хүргүүлж хянуулах шатандаа явж байна. НХҮ-нд тулгамдаж буй асуудлын хүрээнд 2025.04.15-ны өдөр хэлэлцүүлэг сургалтыг хамтран зохион байгуулж АНҮГ, НХҮА болон "МИАТ" ТӨХК зэрэг байгууллагууд оролцсон. Хэлэлцүүлгээс нислэгийн хөдөлгөөний үйлчилгээнд дотоодын агаарын хөлгүүдтэй загварчилсан хэллэгийг хэрхэн ашиглах, онцгой нөхцөл байдлын болон процедурын сэргээх сургалтын үеэр хамтран ажиллах тохиролцоонд хүрсэн.

Иргэний нисэхийн эрэн хайх, авран туслах үйл ажиллагааны үндэсний дадлага, сургуулилтыг зохион байгуулах.

Иргэний нисэхийн эрэн хайх, авран туслах үйл ажиллагааны "Joint sarex 2025" хамтарсан сургуулилтыг зохион байгуулах ерөнхий төлөвлөгөөний төслийг боловсруулан 2025.03.10-ны өдөр батлагдаж, "Хамтарсан сургуулилтыг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах төлөвлөгөө"-ний хүрээнд ИНЕГ болон ОБЕГ-тай хамтран ажиллах санал хүргүүлж, анхны уулзалтыг зохион байгуулсан.

Бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын Сайншанд хотод байгуулах хоёр дахь төвийн ТЭЗҮ-г зөвлөх үйлчилгээгээр хийлгүүлэх ажлыг зохион байгуулах.

Испанийн Хаант Улсын Эдийн засгийн агентлагаас манай улсад олгохоор төлөвлөж буй буцалтгүй тусламжийн санхүүжилтээр төслийн ТЭЗҮ-ийг боловсруулахыг дэмжсэн талаар Сангийн яамнаас 2025.05.28-ны өдрийн 02/5045 тоот албан бичгээр мэдэгдэж байна. Үүний дагуу Зам, тээврийн сайдын 2025.05.30-ны өдрийн 03/2525 тоот албан бичгээр холбогдох журмын дагуу зохион байгуулалтын арга хэмжээ авч "ИНҮТ" ТӨХХК-д даалгасны дагуу Испанийн хаант улсын "Индра" группээс холбогдох гэрээний төслийг авахаар ажиллаж байна.

Нисэхийн мэдээллийн үйлчилгээний эрх олгох сургалтын хөтөлбөрүүдийг олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-ын стандарт шаардлагын дагуу чадамжид суурилсан хөтөлбөрүүд болгон батлуулах.

Нисэхийн мэдээллийн үйлчилгээний чадамжид суурилсан сургалт болон үнэлгээг боловсруулах талаар судалгааны ажил хийгдэж, судалгааны дагуу нисэхийн мэдээллийн үйлчилгээний чиглэлээр ICAO-аас тодорхойлсон чадамжийн загварт нийцүүлэн NOTAM-ын үйлчилгээ, AIP-ын үйлчилгээ, Аэродромын нислэгийн хөдөлгөөний мэдээ зохицуулалтын үйлчилгээний ажлын байранд ажиллах ажилтнуудад шаардлагатай чадамжийг тодорхойллоо. Нийцүүлсэн чадамжийн загварын дагуу сургалт болон үнэлгээний төлөвлөгөө боловсруулах, сургалтын материал бэлтгэх ажил хийгдэж байна.

Монгол Улсын AIP-д хэвлэн нийтлэгдэх 2025 оны соронзон хазайлтын өнцгийн утгын мэдээллийг шинэчлэх төлөвлөгөө боловсруулан батлуулах, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах.

"Соронзон хазайлтын өнцгийн утгын мэдээллийг шинэчлэх ажлын төлөвлөгөө" батлагдсан. Батлагдсан төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааны үнэлгээний хорооноос захиалагчтай гэрээ байгуулах тухай шийдвэрийн саналыг хүргүүлж, гэрээ байгуулах үйл ажиллагааны шатанд явагдаж байна.

Нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллагыг нисэхийн өгөгдөл, нисэхийн мэдээллээр хангах журмыг зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлттэй нийцүүлэн шинэчлэн боловсруулж, батлуулах.

Нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллагыг нисэхийн өгөгдөл, нисэхийн мэдээллээр хангах ерөнхий журамд дүн шинжилгээ хийж 1 үл тохирол, 5 сайжруулах зүйлс илрүүлж, журамд өөрчлөлт оруулсан. Уг журмыг ИНЕГ-ын даргын 2025.05.09-ний өдрийн А/144 дугаар тушаалаар батлуулан, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Digital NOTAM хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан батлуулах, төлөвлөгөөний 2025 оны хэрэгжилтийг хангах.

Digital NOTAM-ыг 5 үе шат, 19 алхамтайгаар хэрэгжүүлэх "Digital NOTAM боловсруулах систем хөгжүүлэлтийн төлөвлөгөө"-г Нисэхийн мэдээллийн үйлчилгээний албанаас боловсруулж батлуулсан бөгөөд 2025 онд шаардлага тодорхойлох, дүрэм журам, системийн архитектурын загварыг боловсруулах, техникийн үзүүлэлтүүдийг тодорхойлох ажлуудыг хийхээр төлөвлөж байна.

Үзүүлэлтэд тулгуурласан навигаци (PBN)-ийн 3 дугаар үе шатыг хэрэгжүүлэх ажлын нарийвчилсан төлөвлөгөөг хэрэгжүүлэх.

Үзүүлэлтэд тулгуурласан навигаци ашигласан (PBN)-ийн 3 дугаар үе шатыг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөний дагуу тасралтгүй өндөр алдах (CDO), тасралтгүй өндөр авах (CCO) нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор DOC 9993, DOC 9931 баримт бичгүүдэд судалгаа хийж, тайлбар гаргасан. Өмнөговь аймгийн Гурвансайхан нисэх буудлын ХБ311/29 талын үзүүлэлтэд тулгуурласан навигаци ашигласан хэрэглэлээр оролт үйлдэх нислэгийн журамд нислэгийн өмнөх баталгаажуулалтаас гарсан өөрчлөлтүүдийг оруулж дуусган, НМҮА-аар зургийн боловсруулалт хийлгэн, нислэгийн өмнөх баталгаажуулалтын дүгнэлтээр "Нислэгээр шалган баталгаажуулах" гэсэн дүгнэлт гарсан тул шалгалтын нислэгээр үнэлэх үйл ажиллагааг 2026 оны төсөвт тусгахаар саналаа оруулсан.

Шалгалтын нислэг болон фотометрийн хэмжлийг хийх төлөвлөгөөг боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх.

"Шалгалтын нислэг болон фотометрийн хэмжлийн 2025 оны төлөвлөгөө"-г боловсруулж, 2025.02.05-ны өдөр батлагдсан. "2025 онд хийгдэх шалгалтын нислэг, фотометрийн хэмжлийн төлөвлөгөө"-нд нийт 8 шалгалтын нислэг, 20 фотометрийн хэмжлийн баталгаажуулалт тусгагдсан. Нисэх буудлуудын ил харааны ойртолтын налуу заагч (PAPI) системд хаврын фотометрийн хэмжилт баталгаажуулалтыг хийж гүйцэтгэсэн, холбогдох газруудад тайланг хүргүүлсэн.

Олон улсын туршлага, хөгжлийн чиг хандлагатай уялдуулан нисэх буудлын үйл ажиллагааг зохион байгуулах чиглэлээр

"Агаарын тээврийг хялбаршуулах зөвлөл"-ийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах.

Агаарын тээврийг хялбаршуулах зөвлөлийн 2025 оны төлөвлөгөөний төсөлд гишүүн байгууллагуудаас санал авч, нэгтгэн 2024.12.13-ны өдөр ИНЕГ-ын Бодлогын хэрэгжилтийн газарт хүргүүлсэн. ИНЕГ-аас 2025.01.08-ны өдрийн 01/51 дугаартай албан бичгээр ЗТЯ-нд хүргүүлж, Зам, тээврийн сайд 2025.01.15-ны өдөр төлөвлөгөөг баталсан. Зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хагас жилийн хэрэгжилтийг 2025.05.28-ны өдрийн байдлаар нэгтгэн 2025.05.28-ны өдрийн 01-5/676 дугаартай албан бичгээр ИНЕГ-т хүргүүлсэн.

"Агаарын хөлөг шувуу, мал, амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх зөвлөл"-ийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах.

Зам, тээврийн яамны А/79 тоот тушаалаар 2025.03.24-ний өдөр "Агаарын хөлөг шувуу, мал, амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх журам" батлагдсан. Агаарын хөлөг шувуу, мал, амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулж, 2025.03.20-ны өдрийн 01-5/276 дугаартай албан бичгээр ИНЕГ-т хүргүүлсэн. Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилт 2025.06.10-ны өдрийн байдлаар 67%-тай байна.

Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх төлөвлөгөөний 2025 оны хэрэгжилтийг хангах.

"Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө" 2025.06.10-ны өдрийн байдлаар 2025 онд хэрэгжүүлэх 13 ажлын гүйцэтгэл дунджаар 60%-тай байна. Иргэний нисэхийн үндэсний төвийн бүтэц зохион байгуулалт ЗТСайдын 2024.12.27-ны өдрийн А/290 тоот тушаалаар өөрчлөлт орсонтой холбоотойгоор тус төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах нэгжүүдийн чиг үүргүүд өөрчлөгдсөн тул ИНЕГ болон "ИНҮТ" ТӨХХК хамтарсан уулзалт хийж Ерөнхий зориулалтын батлагдсан төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулахаар төлөвлөж байна. ЗТЯ-нд 2025.05.13-ны өдрийн 01-5/641 тоот албан бичгээр хэрэгжилтийг нэмэлт өөрчлөлт оруулах саналын хамт хүргүүлсэн.

Орон нутгийн зарим аэродромын даац /PCN/-ыг /PCR/ аргачлалаар аэродромын тооцооллыг хийх.

2025 онд Гурвансайхан нисэх буудлын хөөрч буух зурвасын засвар, Өндөрхаан нисэх буудлын апрон шинээр ашиглалтад орж буйтай холбогдуулан аэродромын даац /PCN/-ыг PCR болгох тооцооллыг хийх нисэх буудлуудыг шинээр тодорхойлсон.

"Чингис хаан" олон улсын нисэх буудалд "шатахуун хангамжийн байгууламж" байгуулах ажлыг эхлүүлэх.

Төв аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2025.02.11-ний 07/121 тоот албан бичгээр холбогдох хууль тогтоомжийн дагуу газрын дуудлага худалдаа зохион байгуулж, агаарын тээврийн барилга, байгууламж, төхөөрөмжийн талбай зориулалттай 3954 м2 газрыг "Сод Монгол Групп" ХХК-д, 4022 м2 газрыг "Интерстандарт Нефть" ХХК-д тус тус олгосон талаар мэдээлсэн. Энэ хүрээнд ЗТСайдын 2025.02.14-ний өдрийн 09/703 дугаартай албан бичгээр дээрх компаниудад "Чингис хаан" олон улсын нисэх буудал дахь агаарын хөлгийн Жет А-1 төрлийн шатахуун хангамжийн агуулах"-ын ажлын даалгаврыг хүргүүлж, төслийг хэрэгжүүлэх тооцоо, судалгааг боловсруулж ирүүлэх талаар мэдэгдэл хүргүүлсэн.

Монгол Улсын Засгийн Газрын 2025.03.06-ны өдрийн 116 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025.03.20-ны өдрийн 136 дугаартай тогтоолуудыг үндэслэн ИНЕГ-ын даргын 2025.03.24-ний өдрийн А/75 дугаартай тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг Шатахуун хангалтын албыг ИНЕГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 54,807,988,166.68 төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийн хамт "Эрчис Ойл" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанид 2025.03.31-ний өдрөөр тасалбар болгон шилжүүлэн хүлээлцсэн.

"Чингис хаан" олон улсын нисэх буудалд "Airport hotel" байгуулах ажлыг эхлүүлэх.

"Чингис хаан" олон улсын нисэх буудлыг түшиглэн байгуулахаар төлөвлөж буй "Airport hotel"-ын ажлын даалгаврыг боловсруулах ажилд холбогдох дэмжлэг үзүүлэх саналыг 2025.04.22-ны өдрийн 01-5/477 дугаартай албан бичгээр ИНЕГ-т хүргүүлсэн. ИНЕГ-ын Бодлогын хэрэгжилтийн газар боловсруулж, ЗТЯ-ны Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан. Зам, тээврийн сайдын 2025.05.23-ны өдрийн 01/2374 дугаар албан бичгээр "Аэрпорт зочид буудал" байгуулах төслийг хэрэгжүүлэх ажлыг хариуцан зохион байгуулахыг "Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал"-д чиглэл өгсөн.

"Буянт-Ухаа" олон улсын нисэх буудлыг түшиглэн хүмүүнлэгийн тусламжийн төв байгуулах ажлыг эхлүүлэх.

"Буянт-Ухаа" олон улсын нисэх буудлыг түшиглэн НҮБ-ийн Дэлхийн Хүнсний хөтөлбөрийн хүрээнд Хүмүүнлэгийн тусламжийн хариу арга хэмжээний төв байгуулахад шаардлагатай хөрөнгө оруулалт татах чиглэлээр ерөнхий судалгааг хийж судалгааны хэрэгжилт 70%-тай байна.

Хэнтий аймаг дахь "Өндөрхаан нисэх буудлыг шинэчлэн барих төсөл"-ийн хэрэгжилтэд хяналт тавих.

Хэнтий аймгийн "Өндөрхаан" нисэх буудлын шинэ барилгыг Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын сайдын 2025.05.02-ны өдрийн 97 дугаар тушаалаар байгуулагдсан 9 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2025.05.08-ны өдөр ажиллаж, дүгнэлтийг /актыг/ 2025.05.28-ны өдөр үйлдэж, ашиглалтад оруулах шийдвэр гаргасан. Барилгын явцад техник, технологийн хяналтыг тавин хэрэгжилтийг ханган ажилласан.

"Шинэ Хархорим" хотод олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-ын "4E" ангилал бүхий нисэх буудал байгуулах ажлын ТЭЗҮ, зураг төслийг боловсруулах.

ИНЕГ-аас "Шинэ Хархорум хотод байгуулах нисэх буудлын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл"-ийг боловсруулахад урьдчилсан байдлаар нийт 3,2 тэрбум төгрөг шаардлагатай талаар судалгаа хийж, саналаа Зам, тээврийн яамны төрийн нарийн бичгийн даргад 2024.11.06-ны өдөр хүргүүлсэн.

Зам, тээврийн яамнаас Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны төрийн нарийн бичгийн дарга С.Төмөрхүүд 3,2 тэрбум төгрөг шаардлагатай талаар төсвийг

шийдвэрлэж өгөх тухай 2025.03.13-ны өдрийн 03/1083 тоот санхүүжилт шийдвэрлүүлэх тухай албан бичгийг хүргүүлсэн.

"Хархорум хотын олон улсын нисэх онгоцны буудлын ТЭЗҮ, барилгажилтын төсөл, аэродромын ажлын зураг төсөл боловсруулах ажлын даалгавар"-ыг ЗТЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны төрийн нарийн бичгийн дарга нар 2025.04.10-ны өдрийн 06/2025/08 тоотоор батлалсан.

Шинэ Хархорум" хотын олон улсын нисэх онгоцны буудлын ТЭЗҮ, барилгажилтын төсөл, аэродромын ажлын зураг төсөл хийх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг /ХББОСЯ/20250103056 дугаар/ 2025.05.29-ний өдөр Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 3,197,500 мянган төгрөгийн нийт төсөвт өртөгтэйгөөр зарласан. Тендерийг 2025.06.27-ны өдөр нээнэ.

"Дэлүүнболдог" нисэх буудлын барилгын ажлын гүйцэтгэлд хяналт тавих, цаашдын ашиглалт, үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулах.

Барилгын эхний хэсгийг "Биг Монголиа" ХХК гэрээ байгуулан гүйцэтгэж байгаа. 2025.03.20-ны байдлаар "Бигмонголиа билдинг" ХХК барилга угсралтын ажилд нийт 15 удаагийн гүйцэтгэлээр 4.983,489,651 төгрөг санхүүжилт авсан. 2024.11.12-ны байдлаар 589,453,516 төгрөгийн үлдэгдэл санхүүжилттэй байна. 2024.12.20-ны өдрийн 01/2024 дугаартай барилга байгууламжийг хүлээж авах комиссын дүгнэлтээр 100 хувь хүлээн авсан. Гэрээт ажлын гэрээ дүгнэгдэж байна. Эцсийн санхүүжилт хийгдээгүй. ЗТЯ-ны ТНБД-ын 2025.06.02-ны өдрийн А/145 дугаартай тушаалаар байгуулагдсан гэрээ дүгнэх ажлын хэсэг "Биг Монголиа билдинг" ХХК-тай байгуулсан "Дэлүүн болдог" нисэх буудлын барилга (Хэнтий, Дадал сум) ажил гүйцэтгэх 181 дугаартай гэрээ"-ний нэмэлт 72 дугаар гэрээг 2025.06.09-ний өдөр дүгнэж, ЗТЯ-нд хүргүүлсэн.

Барилгын 2 дахь хэсгийн ажлыг "Барилга эрч" ХХК гэрээ байгуулан гүйцэтгэж байна. Гэрээний дагуу ажлыг дуусгаж хүлээлгэж өгөх хугацаа 2024.12.20-ны өдөр байсныг ЗТЯ-с 2025.01.14-ний өдөр №УТ2002800921/31 тоот гэрээ байгуулан дуусах хугацааг 2025.07.30 болгож өөрчлөлт оруулан графикийг тодотгосон. 2025.03.20-ны байдлаар "Барилга эрч" ХХК-ний ажлын гүйцэтгэл 23 хувь, 1,168,889,383 төгрөгийн гүйцэтгэлийг баталгаажуулж, 2024 оны 12 сард санхүүжилт олгосон. Зорчигч үйлчилгээний барилгын гадна фасадны үлдэгдэл шил болон гадна металл хавтангийн угсралтын ажлыг 2025.03.25-ны өдрөөс эхлэн барилга угсралтын ажил үргэлжилж байна. Ажлын гүйцэтгэл 30%, санхүүжилтийн гүйцэтгэл 23%-тай байна.

Орон нутгийн зарим нисэх буудлуудын хөөрч буух зурвас, аэродромд засвар хийх.

"ИНҮТ" ТӨХХК-ийн 2025 оны урсгал зардал болон өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, төсөвт Булган сум /Ховд/, Дэлүүнболдог нисэх буудлуудын хөөрч буух зурвас, аэродромд засвар хийх ажлуудын хөрөнгө батлагдаагүй учраас "ИНҮТ" ТӨХХК-ийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд суугаагүй тул дүгнэх боломжгүй, хяналтаас хасуулах саналтай байна.

"Гурвансайхан" нисэх буудал: Төрийн худалдан авах ажиллагааны газрын Үнэлгээний хорооны хурлын шийдвэрээр 2025.03.25-ны өдөр Гурвансайхан нисэх буудлын хөөрч буух хучилттай зурвасын засварын ажлыг гүйцэтгэхээр "Чамбай зам" ХХК шалгарч 2025.04.21-ний өдрийн ИНҮТ/ХО/20250101008 дугаартай гэрээг байгуулан 2025.04.22-ны өдрөөс ажлыг эхлүүлсэн. 2025.06.18-ны өдөр улсын комисс хүлээн авч гэрээг дүгнэж, 2025.06.23-ны өдөр ашиглалтанд оруулсан.

"ИНҮТ" ТӨХХК-ийн бизнес төлөвлөгөөг боловсруулж, батлуулах.

"ИНҮТ" ТӨХХК-ийн 2025 оны бизнес төлөвлөгөө, эдийн засгийн үзүүлэлт, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө боловсруулж, компанийн 2024 оны төсвийн гүйцэтгэл, 2025 оны гүйцэтгэл, хүлээгдэж буй гүйцэтгэл, алба салбаруудын хөрөнгө оруулалт, урсгал зардлын хэтрэлт хэмнэлт, цаашид хэрэгтэй хөрөнгө оруулалт, зардлын саналын дагуу хөрөнгө оруулалтын төлөвлөгөө боловсруулан танилцуулсан. Батлагдсан төсвийн эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшнийг боловсруулан бизнес төлөвлөгөөнд шаардлагатай тоон мэдээллүүдийг гаргасан.

Нийтийн мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу мэдээллийг байгууллагын цахим хуудас, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэх.

Зохион байгуулалтын өөрчлөлттэй холбогдуулан компанийн цахим хуудсыг Нээлттэй мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нийцүүлэн шинэчлэх ажил хийгдэж байна. Үүнд:

Цахим хуудасны бүтэц, агуулгыг шинэчлэн программ хангамжийн хөгжүүлэлтийг хийх ажлын техникийн тодорхойлолт болон нээлттэй мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8-д заасны дагуу тус компанид хамааралтай мэдээ мэдээлэл, мэдээллийг бэлтгэн оруулах албан тушаалтны жагсаалт 2025.02.10-ны өдөр батлагдсан. Ингэснээр цахим хуудсыг 2025.04.15-ны өдөр ашиглалтад оруулж, нэмэлт шинэчлэлт, хөгжүүлэлтийн ажил эрчимтэй хийгдэж байна.

Мөн цахим хуудасны байдлын үйл ажиллагааг хангах журмыг шинэчлэн боловсруулж, 2025.05.08-ны өдрийн А/295 дугаар тушаалаар батлагдаж цахим хуудаст байршуулсан мэдээ, мэдээллийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

ГТҮШХА-ны парк шинэчлэлийг хийх эдийн засгийн үр ашгийн тооцоог боловсруулж, төсөл боловсруулах.

Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын албанаас парк шинэчлэл хийхэд шаардлагатай авто машины судалгаа, хүчин чадал, техникийн үзүүлэлтийн судалгааг хийж суурь судалгаанд үндэслэн парк шинэчлэлийг хийх эдийн засгийн үр ашгийн анхан шатны тооцоо, төслийг 2025.02.07-ны өдөр боловсруулж, танилцуулан дахин шинэчлэл хийж, 2025 оны 5 дугаар сард танилцуулсан. Эдийн засгийн үр ашгийн тооцоог боловсруулж, төслийн хэрэгжилтийн байдал 70%-тай байна.

"Буянт-Ухаа" академи болон Ахмадын хорооны барилгын ажлын даалгавар, зургийн даалгаврыг эскиз зургийн хамт боловсруулах.

Одоо ашиглаж буй Ахмадын өргөөний барилгын хажуу талбайд 3 давхар барилга барих төсөөллийг хийж, зургийн ажлын даалгаврыг боловсруулсан. "Буянт-Ухаа" академи болон Ахмадын хорооны барилгын зургийн даалгаврыг, ерөнхий скиз зургийн хамт 2025.03.20-ны өдөр боловсруулсан.

Зураг төсвийг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 2025.03.20-ны өдөр зарлаж, 2025.04.06-ны өдөр нээж, гүйцэтгэгчээр "Гиптноз дизайн" ХХК шалгарч гэрээг 2025.05.13-ны өдөр байгуулсан.

Иргэний нисэхийн салбарт хэрэгжих төсөл хөтөлбөрүүдийн санхүүжилтийн эх үүсвэр, хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэх.

2025 онд "ИНҮТ" ТӨХХК-д хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн жагсаалтыг гаргаж 2025.04.15-ны өдрийн 01-11/424 дугаартай албан бичгээр ЗТЯ-нд хүргүүлсэн. 2025 онд компанид хэрэгжүүлэх 29 төсөл хөтөлбөрийн жагсаалтыг гаргаж, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан 2025.06.04-ний өдөр танилцуулсан. "Буянт-Ухаа" ОУНБ-д ГТҮШХА-ны тусгай зориулалтын тоног төхөөрөмжийг ашиглах, нэмэгдүүлэх замаар агаарын хөлгийн

талбайн үйлчилгээ үзүүлж, орлогыг нэмэгдүүлэх төслийг 2025.02.07-ны өдөр боловсруулсан. Хөрөнгө оруулалт татах чиглэлээр судалгааны ажил хийгдэж байна.

"Жаргалант" амралтын үйл ажиллагааг өргөжүүлэх, сайжруулах.

"Жаргалант" сэргээн засах амралтын үйл ажиллагааг өргөжүүлэх, сайжруулахаар 2025.03.10-ны өдөр төсөл, бизнесийн загварчлалыг одоогийн нөхцөл байдалтай уялдуулан бизнесийн стратеги төлөвлөгөө, төслийг боловсруулсан. "Жаргалант" сэргээн засах амралтын газарт тавилга, тоног төхөөрөмж худалдаж авах техникийн тодорхойлолт, ажлын даалгаврыг боловсруулж, үнэлгээний хороо байгуулагдсан. Тендерийг 2025.04.29-нд зарлаж 2025.05.06-нд нээж үнэлэхэд шаардлагад нийцсэн тендер ирээгүй тул 2025.06.04-ний өдөр дахин зарлаж 2025.06.20-нд нээхээр ажиллаж байна.

"Буянт-Ухаа" олон улсын нисэх буудлыг төрийн өндөр дээд хэмжээний айлчлал хүлээн авахад зориулан тохижуулах.

Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025.02.26-ны өдрийн 03/919 дугаар албан бичгээр "Буянт-Ухаа" олон улсын нисэх буудлын дээвэр, гадна фасад, хүлээлгийн танхимын их засварын ажлыг шуурхай зохион байгуулж, засвар тохижилтийн ажлыг 05 дугаар сард багтаан дуусгах чиглэл өгсөн. Чиглэлийн дагуу хэрэгжүүлж буй ажлын тайланг 2025.03.19-ний өдрийн 01-5/261 дугаартай албан бичгээр ЗТЯ -нд хүргүүлсэн.

Төрийн худалдан авах ажиллагааны газраас зарласан ИНҮТ/20250101007 дугаартай "Буянт-Ухаа" ОУНБ-ын дээвэр, гадна фасад, хүлээлгийн танхимын их засварын ажил төсөл, арга хэмжээний Багц-1 буюу "Буянт-Ухаа" ОУНБ-ын дээврийн ажлыг гүйцэтгэх тендерт "Мөнххархираа" ХХК шалгарч, гэрээ байгуулсан. Багц-2 буюу "Буянт-Ухаа" ОУНБ-ын гадна фасадны ажлын үйл явц хянагдаж байгаа бөгөөд харин Багц-3 буюу "Хүлээлгийн танхимын их засварын ажил"-ын тендерт "Урал Их" ХХК шалгарсан ба гэрээг байгуулсан.

<u>Олон улсын иргэний нисэхийн байгууллагаас тавигдсан стандарт шаардлагад нийцсэн иргэний нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйл ажиллагааг хангах чиглэлээр.</u>

АНУ-ын нислэг эхлүүлэхтэй холбоотой эрх зүйн баримт бичигт өөрчлөлт оруулж, шаардлагатай орон тооны судалгаа хийх.

АНУ-ын TSA-ны Үйл ажиллагааны заавар (SOP)-аас холбогдох хэсгийг Нисэхийн аюулгүй байдал, хамгаалалтын албаны "Аюулгүйн хамгаалалтын ерөнхий заавар"-т нэмэлт өөрчлөлтөөр тусган боловсруулж, 2025.03.07-ны өдрийн 01-6/224 дугаартай албан бичгээр Иргэний нисэхийн ерөнхий газарт хүргүүлсэн. ИНЕГ-аас 2025.05.01-ний өдөр нэмэлт өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөн тухай 2025.05.05-ны өдрийн 01/750 дугаартай албан бичгээр ирүүлсэн.

АНУ-ын Тээврийн аюулгүй байдлыг хангах захиргаанаас "Чингис хаан" ОУНБ-ын аюулгүйн хамгаалалтын үйл ажиллагаанд үнэлгээ хийх ажлын хэсгийн хөтөлбөрт тусгагдсаны дагуу "Нисэхийн аюулгүйн хамгаалалтын чухал мэдээллийг хамгаалах журам"-ыг шинээр боловсруулж, батлуулсан.

АНУ-ын Тээврийн аюулгүй байдлыг хангах захиргаа (TSA)-ны холбогдох чиглэл хариуцсан албан тушаалтнуудтай тогтмол хамтран ажиллаж байна. Тус ажлын хүрээнд 2023 оны АНУ-ын TSA-хийгдсэн Аудитын зөвлөмж, 2024 онд хийсэн "Чингис хаан" ОУНБ-ын олон улсын аюулгүйн үзлэгийн цэгүүдийн төлөвлөлт, шаардлагатай хүний нөөц, тоног төхөөрөмжийн хэрэгцээг тодорхойлсон зөвлөмжүүд болон "United Airlines" компанитай 2025.04.29-ний өдөр байгуулсан "Зорчигчийн аюулгүй байдлын үзлэгийн үйлчилгээний хураамж төлөх гэрээ" зэргийг

үндэслэн шаардлагатай орон тооны судалгааг боловсруулсан. Компанийн ТУЗ-д танилцуулах шатандаа явагдаж байна.

АНУ-ын нислэг эхлүүлэхтэй холбоотойгоор ажилтнуудыг сургалтад хамруулах.

Монгол улс АНУ-ын хооронд шууд нислэг эхлүүлэх бэлтгэл ажлын хүрээнд Юнайтэд Эйрлайнс компаний багш нар аюулгүйн хамгаалалтын 97 ажилтанд карго, катеринг, агаарын хөлгийн гадна болон дотор талын үзлэг сэдэвт сургалтыг 2025.04.26-2025.05.01-ний өдрийн хооронд зохион байгуулж, ажилтнуудыг дадлагажуулсан. Монгол улс АНУ-ын хооронд шууд нислэг эхлүүлэх бэлтгэл ажлын хүрээнд 2025.03.19-21-ний өдрүүдэд Аюулгүйн үзлэгийн 60 ажилтанд "Зөвшөөрөгдөөгүй эд зүйлс бодитоор таниулах, Биет үзлэг" сэдэвт ажлын байрны сургалтыг тус тус зохион байгуулсан. 2025.03.19, 21-ний өдрүүдэд Үзлэг шалгалтын хэсгийн 42 ажилтанд "Itemiser-5X dual view рентген аппарат"-ны сургалтыг зохион байгуулсан.

<u>Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, компанийн засаглал, хүний нөөцийн удирдлагыг оновчтой хэрэгжүүлж, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх чиглэлээр</u>

"ИНҮТ" ТӨХХК-ийн "Хөдөлмөрийн дотоод журам", "Үйл ажиллагааны ерөнхий журмууд"-ыг батлуулж, мөрдөж ажиллах.

"Хөдөлмөрийн дотоод журам", "Цалин хөлсний журам", "Үйл ажиллагааны ерөнхий журам", "Хөдөлмөрийн гэрээ"-г хууль тогтоомжийн хүрээнд шинэчлэн боловсруулж, компаний "Хөдөлмөрийн дотоод журам"-ыг 2025.02.07-ны өдрийн А/40 дугаар тушаалын дагуу харин А/41 дүгээр тушаалаар "Цалин хөлсний журам"-ыг тус тус батлан нийт ажилтнуудад танилцуулан үйл ажиллагаанд мөрдөн ажиллаж байна. 2025.02.21-ний өдрийн А/77 дугаар тушаалаар захиргаа, санхүү, хууль, эрх зүйн чиглэлийн үйл ажиллагаанд дагаж мөрдөх дүрэм, журам, заавар, бодлогын баримт бичиг, хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, танилцуулах нийт 23 дүрэм, журам, заавар, бодлогын баримт бичгийг боловсруулан 2025.05.08-ны өдрийн захирлын зөвлөлийн 4 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлсэн бөгөөд зөвлөлийн хуралдаанаас 13 журмыг баталж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Иргэний нисэхийн ерөнхий газрын Хүний нөөцийн стратегийн 2024-2028 он хүртэл хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах.

"ИНЕГ-ын Хүний нөөцийн стратегийг 2024-2028 он хүртэл хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний 2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилт 2025.06.10-ны өдрийн байдлаар 83.7%-ийн биелэлттэй байна.

Монгол Улсад Нисэх хүчин үүсэж хөгжсөний 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх.

Зам, тээврийн яам болон Батлан хамгаалах яам хамтран 45 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг 2025.02.28-ны өдөр баталсан. 2025.05.15-ны өдрийн байдлаар төлөвлөгөөний хэрэгжилт 100%-тай байна. Монгол Улсад Нисэх хүчин үүсэж хөгжсөний 100 жилийн ойг тэмдэглэн 2025.05.19-05.25-ны өдрүүдэд амжилттай тэмдэглэн өнгөрүүлсэн.

Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын бүртгэл судалгааг хөтөлж, шийдвэрлэж, тайлагнах.

Иргэдийн өргөдөл, гомдлыг цахим болон бичгээр хүлээн авч, IMCAA системд бүртгэн, холбогдох нэгжид шилжүүлэх, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн явцад хяналт тавьж ажиллаа. Тайлант хугацаанд иргэд болон ажилтнуудаас нийт 671 өргөдөл, гомдлыг ирүүлсэн ба шийдвэрлэгдсэн 636, шийдвэрлэх шатанд байгаа 26, хугацаа хэтэрсэн 9 өргөдөл байна. Шийдвэрлэлт 96.7%-тай байна.

Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах.

Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах ерөнхий төлөвлөгөөнд салбар, нэгжүүд болон орон нутгийн нисэх буудлуудаас санал авч нэгтгэн, батлуулахаар ажиллаж байна.

2025 оны гадаад, дотоод сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах.

Нисэхийн сургалтын төвд 2025 онд зохион байгуулах дотоод сургалтын төлөвлөгөөг 2025.01.14-ний өдөр батлуулж, хэрэгжүүлэн ажиллаж байна. Төлөвлөгөөний хэрэгжилт 2025.05.31-ний өдрийн байдлаар 29 сургалтыг зохион байгуулж 1493 ажилтныг хамруулсан байна. Тус төлөвлөгөөний хүрээнд 2025.06.05-ны өдрийн байдлаар 4 төрлийн төлөвлөгөөт сургалтад 6, 5 төрлийн тэтгэлэгт сургалтад 28, 1 хичээл, үйлдвэрлэлийн дадлага сургалтад 5, нийт 39 ажилтныг гадаад сургалтад хамруулж, гэрчилгээжүүлсэн. Төлбөртэй дотоод сургалтын төлөвлөгөөг 2025.05.07-ны өдөр батлуулж, хэрэгжүүлэн ажиллаж байна. Төлөвлөгөөний дагуу 5 сургалтад 11 ажилтныг хамруулсан.

ICAO-аас баталгаажсан стандартчилагдсан сургалтын багц (ITP, STP) хөтөлбөрийн сургалтуудыг Нисэхийн сургалтын төвд зохион байгуулж, хүний нөөцийг дотооддоо мэргэшүүлэх.

"Нисэхийн сургалтын төвийн 2025 оны орлого, зардлын төлөвлөгөө"-г 2025.04.24-ний өдөр батлуулсан бөгөөд "Trainair plus" хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах сургалтуудын зардал батлагдсан. Батлагдсан төсвийн хүрээнд сургалтуудыг зохион байгуулах хүсэлтийг Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-д хүргүүлж, зөвшөөрөл авсан.

"ИНҮТ" ТӨХХК-ийн захирлын 2025.06.02-ны өдрийн А/334 тоот тушаалын дагуу Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-ын стандартчилагдсан сургалтын багц хөтөлбөрийг заах багшийг бэлтгэх "Training Instructor Course" 212/002/TIC EN олон улсын сургалтыг 2025.06.09-2025.06.13-ны хооронд амжилттай зохион байгуулж, ICAO-ийн гэрчилгээг 10 багшид олгоод байна.

Цаашид НСТ-ийн үндсэн болон гэрээт багш нарт ICAO-аас багшид тавигддаг шаардлагыг бүрэн хангуулах үйл ажиллагааг дотооддоо хариуцан зохион байгуулах, олон улсын болон ICAO-ын сургалтуудыг Монгол улсад чанарын өндөр түвшинд зохион байгуулах боломжийг бүрдүүлэн ажиллана.

"ИНҮТ" ТӨХХК-ийн харьяа салбар, нэгжийн ажилтнуудыг олон улсын тэтгэлэгт сургалтад хамруулах үйл ажиллагааг нээлттэй, үр дүнтэй зохион байгуулах.

Зарлагдсан тэтгэлэгт сургалтуудад 11 ажилтны танилцуулах хуудас, nomination form болон бусад шаардлагатай баримт бичгийн боловсруулалтыг хийн, ИНЕГ-ын даргаар батлуулж, холбогдох байгууллагад хугацаанд нь хүргүүлсэн. 2025.05.20-ны өдрийн байдлаар 2 ажилтан тэтгэлэгт сургалтад тэнцээд байна. Тайлант хугацаанд TEAC/TEAP шалгалтад 31 нисгэгч, нислэгийн удирдагч хамрагдсан бөгөөд ИНЕГ-т дүнг хүлээлгэн өгсөн.

Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хэрэгжүүлэх.

Зам, тээврийн сайдын 2024.12.16-ны өдрийн А/273 дугаар тушаалаар батлагдсан удирдамжийн дагуу Иргэний нисэхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн хэрэгжилтийг хангах зорилгоор дараах ажлуудыг хийж хэрэгжилтийг ханган ажилласан.

Зам, тээврийн сайдын 2024.12.27-ны өдрийн А/290 дүгээр тушаалаар "ИНҮТ" ТӨХХК-ийн дүрэм, зохион байгуулалтын бүтэц орон тоог баталсан ба Шатахуун хангалтын албыг "Эрчис ойл" ТӨХК-д шилжүүлсэнтэй холбогдуулан компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025.05.29-ний өдрийн шийдвэрээр зохион байгуулалтын бүтэц, орон тоонд нэмэлт өөрчлөлт оруулсан.

Хуулийн шинэчилсэн найруулгатай холбогдуулан компанийн бодлогын баримт бичиг, албан тушаалын тодорхойлолт, компанийн дотоод журам болон үйл ажиллагааны дүрэм, журам, шинэчлэн боловсруулж, батлуулан үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаж байна.

"ИНҮТ" ТӨХХК нь гэрчилгээжсэн үйлчилгээ үзүүлдэг 8 алба нэгжтэй бөгөөд одоогоор 7 алба нэгж амжилттай гэрчилгээжсэн ба Буян-Ухаа Олон улсын нисэх буудал гэрчилгээжих процесс явагдаж байгаа болно.

Хуулийн шинэчлэлтээр "Иргэний нисэхийн үндэсний төв" нь төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани болж өөрчлөн байгуулагдсантай холбоотойгоор Иргэний нисэхийн ерөнхий газрын балансаас барилга байгууламж, тоног төхөөрөмж, эд хөрөнгийг шилжүүлэн авах ажлын хүрээнд Гүйцэтгэх захирлын 2025 оны А/224 дүгээр тушаалаар "Тооллогын комисс"-ыг байгуулж, хөрөнгийн тооллого хийж, нэгдсэн тайланг компанийн Өмч хамгаалах байнгын зөвлөлд танилцуулж, 2025.06.03-ны өдөр Иргэний нисэхийн ерөнхий газарт хүргүүлсэн.

Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж, тайлагнах.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам", 2025 оны "Хуулийн хэрэгжилтийг хангах тухай" А/201 дүгээр тушаал, "Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, мэдээ байршуулах үүргийг шилжүүлэх тухай" А/350 дугаар тушаалаар батлагдсан.

Компанийн шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл байршуулах албан тушаалтан, түүний гүйцэтгэх чиг үүрэг, ажлын хуваарийн дагуу тус газрын нэгжүүдээс 15 нэр төрлийн мэдээ, мэдээллийг shilendans.gov.mn сайтад байршуулан ажилласан бөгөөд нийт 157 мэдээлэл байршуулахаас 2025.06.05-ны өдрийн байдлаар 58 мэдээллийг хугацаандаа мэдээллэсэн ба хугацаа хоцроосон 1 мэдээлэл байна.

Хугацаа хоцорч мэдээллэсэн төлөвтэй мэдээлэл нь "Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө"-г жил бүрийн 01.10-ны өдрийн дотор мэдээлэх хуулийн хугацаатай боловч уг төлөвлөгөө нь компанийн бүтцийн өөрчлөлттэй холбоотойгоор 2025.01.28-ны өдөр батлагдсаныг 2025.01.29-ний өдөр шилэн дансны цахим системд ил тодоор мэдээллэсэн болно.

"Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт"-ийг хангаж ажиллах зорилгоор "Иргэний нисэхийн үндэсний төв" ТӨХХК болон салбар нэгжүүдийн шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэлд хяналт тавьж, тайланг нэгтгэн хуулийн хугацаанд Зам, тээврийн яаманд 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар, 2025.04.15-ны өдөр хүргүүлсэн.

<u>Санхүүгийн ил тод байдлыг хангаж, орлогыг нэмэгдүүлж, компанийн санхүүг үр ашигтай удирдан зохион байгуулах чиглэлээр</u>

ИНҮТ-ийн хөрөнгө оруулалтаар болон урсгал зардлаар хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээг хуулийн хугацаанд хэрэгжүүлэх.

"Иргэний нисэхийн үндэсний төв" ТӨХХК-ийн 2025 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2025.01.28-ны өдөр баталсан. Тус төлөвлөгөө нь "Иргэний нисэхийн үндэсний төв" ТӨХХК-ийн 2025 оны өөрийн орлого болон урсгал зардлаар санхүүжүүлэн шинээр хэрэгжүүлэх 48,2 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 136 төсөл, арга хэмжээ, 2024-2025 онд он дамжин хэрэгжиж буй 9,3 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 33 төсөл, арга хэмжээтэйгээр батлагдсан. Он дамжин хэрэгжиж байгаа 33 төсөл арга хэмжээнээс 25 нь бүрэн хэрэгжиж дууссан, гэрээг дүгнэсэн байна.

Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд "Иргэний нисэхийн үндэсний төв" ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлын 2025.01.28-ны өдрийн 01/94 дугаар албан бичгээр тус компанийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 28,3 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 5 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг Төрийн худалдан авах ажиллагааны газарт шилжүүлсэн.

Тайлант хугацаанд 38.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 75 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, холбогдох дүрэм журмын дагуу төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр нээлттэй зохион байгуулж ажилласан ба гэрээ байгуулсан 17, гэрээ байгуулах эрх олгосон 22, тендерийг нээн үнэлж байгаа 23, тендер хүлээн авч байгаа 13 төсөл, арга хэмжээ байна.

ИНҮТ болон харьяа салбар, нэгжийн эд хөрөнгийн эзэмшил ашиглалт, хадгалалт хамгаалалтад хяналт тавьж, хөрөнгөд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.

"Иргэний нисэхийн үндэсний төв" ТӨХХК-д 2025.04.30-ны өдрийн байдлаар нийт 26.9 сая ширхэг 759,603.7 сая төгрөгийн өртөгтэй, 239,272.7 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, 520,331.0 сая төгрөгийн үлдэгдэл өртөгтэй үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна. 2025.03.28-ны өдрийн А/158 дугаар тушаалаар Өмч хамгаалах байнгын зөвлөлийг байгуулсан ба тайлант хугацаанд уг зөвлөлийг 2 удаа хуралдуулан, компанийн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой шийдвэрийг гаргаж ажилласан.

"Иргэний нисэхийн үндэсний төв" ТӨХХК-ийн харьяа Шатахуун хангалтын албыг барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, хүний нөөцийн хамт "Эрчис Ойл" ТӨХХК-ийн харьяанд шилжүүлэхтэй холбоотой бэлтгэл ажлыг хангах хүрээнд Шатахуун хангалтын албанд бүртгэлтэй хөрөнгийн жагсаалтыг гаргах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 2025 оны А/120 дугаар тушаалаар байгуулсан ба ажлын хэсгийн зохион байгуулсан тооллогоор илүүдсэн 94,405.24 кг шатахууныг орлогод бүртгэх, Шатахуун хангалтын албаны санхүүгийн бүртгэлд бүртгэлтэй 6,256,937,124.02 төгрөгийн бараа материал, сэлбэг хэрэгслийг "Эрчис ойл" ТӨХХК-д шилжүүлэх асуудлаар 2025.03.31-ний өдөр Өмч хамгаалах байнгын зөвлөлд тайланг танилцуулж, уг зөвлөлийн шийдвэрийн дагуу 2025 оны "Шатахуун хангалтын албыг шилжүүлэхтэй холбоотой зарим арга хэмжээг авах тухай" А/161 дүгээр тушаал гарсан.

Мөн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024.02.27-ны өдрийн "Хөрөнгө шинэчлэн бүртгэх зөвшөөрөл олгох тухай" 86-р тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2025.03.06-ны өдрийн "Үл хөдлөх хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай" 116 дугаар тогтоолын дагуу Чингис хаан олон улсын нисэх буудалд байрлалтай Шатахуун хангалтын албаны нийт 25 ширхэг, 36,230.2 сая төгрөгийн балансын үнэтэй, 7,019.9 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэл, 29,210.4 сая төгрөгийн үлдэх өртөг бүхий барилга, байгууламж, газар, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025.03.20-ны өдрийн "Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай" 136 дугаар тогтоолын дагуу 739 ширхэг 18,577.8 сая төгрөгийн балансын үнэ, 8,106.4 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэл, 10,471.3 сая төгрөгийн үлдэх өртөг бүхий тоног төхөөрөмж, тавилга, тээврийн хэрэгслийг "Эрчис ойл" ТӨХХК-д тус тус шилжүүлсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2024.11.27-ны өдрийн 193 дугаар тогтоолоор "Иргэний нисэхийн үндэсний төв" нь Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани болж өөрчлөн байгуулагдсантай холбоотойгоор Иргэний нисэхийн ерөнхий газрын балансаас барилга байгууламж, тоног төхөөрөмж, эд хөрөнгийг шилжүүлэн авах бэлтгэл ажлыг хангах, "Иргэний нисэхийн үндэсний төв" ТӨХХК, салбар, нэгжийн эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж, тооллого хийх зорилгоор хөрөнгийн тооллого зохион байгуулах комиссыг 2025 оны А/224 дүгээр тушаалаар байгуулсан. Тооллогын

комисс компанийн хэмжээнд тооллогыг зохион байгуулж, салбар, нэгжүүдээс ирүүлсэн тайланг нэгтгэсэн ба тооллогын комиссын тайланг 2025.05.30-ны өдөр Өмч хамгаалах байнгын зөвлөлд танилцуулж, 2025.06.03-ны өдрийн 02-9/760 дугаартай албан бичгээр Иргэний нисэхийн ерөнхий газарт хүргүүлсэн.

Өр авлагыг барагдуулах.

"ИНҮТ" ТӨХХК-ийн нэгтгэсэн санхүүгийн тайланд 2025.01.01-ний өдрийн авлагын эхний үлдэгдэл 9.2 тэрбум төгрөг, өглөгийн эхний үлдэгдэл 222.45 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба мөн оны 04.18-ны өдрийн байдлаар авлагын үлдэгдэл 9.9 тэрбум төгрөг, өглөгийн үлдэгдэл 1.2 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Нэгтгэсэн авлага, өглөгийн үлдэгдлийг санхүүгийн тайлангийн үзүүлэлтээр харуулбал:

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл 2025-01-01	Эцсийн үлдэгдэл 2025-04-18	Зөрүү /өссөн +, буурсан - /
Авлага:				
1	Дансны авлага	7,222,550,660.63	6,318,533,709.96	- 904,016,950.67
2	Татвар, НДШ-ийн авлага	40,284,330.02	435,432,689.98	395,148,359.96
3	Бусад авлага	1,932,416,823.24	3,144,851,218.17	1,212,434,394.93
	Дүн	9,195,251,813.89	9,898,817,618.11	703,565,804.22
Өглөг:				
1	Цалингийн өглөг	198,766.86	0	- 198,766.86
2	Татварын өр	97,407,017.13	361,715,222.53	264,308,205.4
3	НДШ - ийн өглөг	3,842,514.83	115,445,352.56	111,602,837.73
4	Бусад богино хугацаат өр төлбөр	121,002,500.36	738,251,408.42	617,248,908.06
	Дүн	222,450,799.2	1,215,411,983.51	992,961,184.33

Барагдах боломжгүй буюу ажлаас чөлөөлөгдсөн болон хүүхэд асрах чөлөөтэй байгаа ажилтнуудад олгосон, тэднээс авах авлага 24,0 сая төгрөг, Шүүхээр хүчингүй болгосон, найдваргүй авлага 91,7 сая төгрөг, Шүүхэд нэхэмжлэл гаргасан, эсвэл гаргахаар хуулийн хэлтэст хэлэлцэж байгаа авлага 23,0 сая төгрөг, эдгээр 3 асуудлын хүрээнд 140 орчим сая төгрөгийн авлагыг ТӨБЗГ-ын шийдвэрт найдваргүй авлага гэж дурдуулах;

"Аэромонголиа" ХХК-тай холбоотой 704 сая, Зам, тээврийн яамтай холбоотой 38 сая, нийт 743 сая төгрөгийн авлагыг ИНЕГ-т үлдээх саналыг тус тус хөрөнгийн тооллогын тайлангийн дүгнэлтэд тусган, Өмч хамгаалах байнгын зөвлөлд танилцуулан, холбогдох дээд шатны байгууллагуудад хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

ОРЛОГО НЭМЭГДҮҮЛЭХ, ЗАРДАЛ ХЭМНЭХ, БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Монгол Улсын Засгийн Газрын 2025 оны 132 дугаар тогтоолоор төрөөс иргэн хуулийн этгээдэд үзүүлж байгаа бүх төрлийн үйлчилгээний төлбөр, хураамжийг 2025 оны төсвийн жилд нэмэгдүүлэхгүй байхыг зөвлөсөн. Иймд орлого нэмэгдүүлэхтэй холбогдуулан "Иргэний нисэхийн үндэсний төв" ТӨХХК-ийн харьяа алба салбаруудын үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэхээр 2025 оны 6 сард 27, 28, 29, 30, 31 дугаар албан бичгээр санал авч нэгтгэн шинээр 43 төрлийн үйлчилгээг үзүүлэх тооцоо судалгааг хийж ажиллаж байна.

"Иргэний нисэхийн үндэсний төв" ТӨХХК нь Монгол Улсын нутаг дэвсгэрт болон агаарын зайд нисэхийн аюулгүй байдлыг хангасан, хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, аюулгүй, үр ашигтай, тогтвортой, хүртээмжтэй орчин үеийн дэвшилтэт технологид суурилсан үйлчилгээ үзүүлэх зорилгоор компанийн дунд хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулан, батлуулахаар ажиллаж байна. Энэхүү стратеги төлөвлөгөө батлагдсанаар санхүүгийн тогтвортой байдал болон үр ашгийг дээшлүүлж, улмаар компанийн орлого нэмэгдэж, зардал буурах юм.

Орон нутгийн нисэх буудлуудын нисэхийн болон нисэхийн бус орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх боломжтой төсөл хөтөлбөр, санал санаачилгыг авч нэгтгэн "ИНҮТ" ТӨХХК-д хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн жагсаалтыг гаргаж 2025.04.15-ний өдрийн 01-11/424 дугаартай албан бичгээр ЗТЯ-нд хүргүүлсэн.

ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

"Иргэний нисэхийн үндэсний төв" ТӨХХК-ийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө 7 зорилтын хүрээнд 60 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан. Төлөвлөгөөний хэрэгжилт энэ оны хагас жилийн байдлаар бүрэн хэрэгжиж дууссан 3 /1.1, 3.7, 3.9/, хэрэгжилтийн шатандаа 55, хяналтаас хасуулах саналтай 2 арга хэмжээ байна. Нийт 86,8% (Дотоод аудит хянасан)-тай байна.

Хүснэгт 1 /II улирлын хэрэгжилт хувиар/

Нийт заалт	Үүнээс						Хувь
	100%	70%	50%	30%	0%	Хугацаа болоогүй	
60	41	10	7	2	0	0	86,8%

Удаашралттай буюу 30%-ийн хэрэгжилттэй 2 /2.5, 3.5./ арга хэмжээ байна.

1. 2.5 Иргэний нисэхийн эрэн хайх, авран туслах үйл ажиллагааны үндэсний дадлага, сургуулилтыг зохион байгуулах.
   Зорилтот түвшин: Хагас жилийн байдлаар: I улиралд: Төлөвлөгөөний хэрэгжилтийг 30 хувьд хүргэсэн байна. II улиралд:Төлөвлөгөөний хэрэгжилтийг 50 хувьд хүргэсэн байна.
   Хэрэгжилт: Төлөвлөгөөнд нийт 9 ажил тусгагдсанаас хэрэгжилтийн хувь 2025.05.31-ний өдрийн байдлаар 2 ажил 100% бусад ажил хийгдээгүй. 22,0%-тай байна.

2. 3.5.Орон нутгийн зарим аэродромын даац /PCN/-ыг PCR аргачлалаар аэродромын тооцооллыг хийх.
   Зорилтот түвшин: II улиралд: PCR аргачлалаар аэродромын тооцоолол хийх жагсаалтыг хийсэн байна. II улиралд:1 аэродром
   Хэрэгжилт: Гурвансайхан нисэх буудлын хөөрч буух зурвас. 30%-тай байна.

БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АЖЛУУД

- Монгол Улсын Засгийн газар болон Арабын эдийн засгийн хөгжлийн Кувейтийн сангийн хооронд байгуулсан хэлэлцээрийн хүрээнд 3.5 сая ам.долларын буцалтгүй тусламжийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн Хэнтий аймгийн "Өндөрхаан нисэх буудлыг шинэчлэн барих төсөл" нь 2020 оноос эхэлж, гурван багц ажлаар амжилттай хэрэгжиж, 100 хувийн гүйцэтгэлтэйгээр ашиглалтад орсон. Шинэ нисэх буудал нь 1438 м² талбай бүхий зорчигч үйлчилгээний барилга, 516 м² талбай бүхий газрын үйлчилгээний гарааш, инженерийн дэд бүтэцтэй, Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-ын 3С

ангиллын шаардлага хангасан, цагт 50 зорчигч хүлээн авах хүчин чадалтай болсон нь бүс нутгийн ард иргэд, зочид гийчдэд иргэний агаарын тээврийн үйлчилгээг үзүүлэх таатай орчин нөхцөлийг бүрдүүлсэн нь орон нутаг тедийгүй улс орны хэмжээнд нийгэм, эдийн засгийн үзүүлэлтийг нэмэгдүүлэх, аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлж байна.

- Өмнөговь аймгийн "Гурвансайхан" нисэх буудлын аэродромын хөөрч буух хатуу хучилттай зурвасын шинэчлэлийн ажлыг гүйцэтгэж ашиглалтанд оруулсан. 1957 оноос хойш дорвитой засвар хийгдээгүй тус нисэх буудлын зурвасыг шинэчилснээр говийн бүс нутагт уул уурхай, аялал жуулчлалын хуваарьт болон захиалгат нислэгүүд нэмэгдсэн.
- "Буянт-Ухаа" ОУНБ-ын 29000м2 талбайд автомашины зогсоол, зам засварын ажлыг 2025.05.09-2025.05.24-ний өдөр хүртэл 15 хоногийн хугацаанд гүйцэтгэн замын хөдөлгөөнийг нээсэн. Мөн дээрх хугацаанд "Буянт-Ухаа" ОУНБ-ын төгөл болон шороон зогсоолын хашлагыг сэргээн засварлах, далангийн төмөр шатыг шинэчлэн засварлах ажил, нисэх буудлын ногоон төглийн усжуулалтын системийг шинэчлэн, нисэх буудлын гэрэлтүүлгүүдийг шинэчлэх ажлуудыг гүйцэтгэж дуусгасан.
- "Иргэний нисэхийн үндэсний төв" ТӨХХК Сингапур Улсын SP Engineering-тэй хамтран "Аэродром, Ойртолтын нислэгийн хөдөлгөөний удирдлагын дадлагажуур"-ын шинэчлэлтийн ажлыг амжилттай хэрэгжүүлж, орчин үеийн шаардлагад нийцсэн сургалтын системийг хүлээн авлаа. Шинэчлэл нь зөвхөн анхан шатны сургалтад бус, нислэгийн удирдагчдын давтан сургалт, онцгой нөхцөл байдлын бэлэн байдлын бэлтгэл, ажлын байрны дадлагын өмнөх сургалтад өргөн хүрээтэйгээр ашиглагдах боломжийг бүрдүүлж байгаа бөгөөд энэ нь Монгол Улсад нислэгийн хөдөлгөөний удирдагч бэлтгэх чадамжийг олон улсын түвшинд ахиулах чухал алхам болж байна.

ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААГ ХЭРХЭН ӨРГӨЖҮҮЛСЭН

Иргэний нисэхийн агаарын навигацийн үйлчилгээний байгууллага /КАНСО/-гийн Ази номхон далайн бүсийн төвийн дарга ноён Со Потинтой 2025.05.26-ны өдөр тус байгууллагын удирдлагын төлөөлөл уулзалт хийсэн. Уулзалтын үеэр Монгол Улсын "Иргэний нисэхийн үндэсний төв" ТӨХХК болон "КАНСО"-гийн цаашдын хамтын ажиллагаа улам өргөжин тэлж, хүний нөөцийг чадавхжуулах, туршлага солилцох чиглэлээр хамтын ажиллагаагаа өргөжүүлэх талаар санал солилцсон.

Олон улсын нисэх буудлуудын холбоо /ACI/-ны Ази, номхон далай, ойрхи дорнодын бүс хариуцсан захирал ноён Стефано Барончийг хүлээн авч уулзан агаарын тээврийг хялбаршуулах, аюулгүйн хамгаалалт, аэродромын ашиглалт, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх чиглэлээр хамтын ажиллагааг өргөжүүлэх мөн "Иргэний нисэхийн үндэсний төв" ТӨХХК-ийн төлөөллийг Олон улсын нисэх буудлуудын холбоо /ACI/-ны Ази, номхон далай, ойрхи дорнодын бүсийн зөвлөлийн бүрэлдэхүүнд оруулж ажиллуулах зэрэг асуудлаар санал солилцов.

Монгол Улсын "Иргэний нисэхийн үндэсний төв" ТӨХХК, Бүгд Найрамдах Солонгос Улсын Газрын тосны чанар хангамжийн газар хооронд 2025.05.24-ний өдөр "Техникийн хамтын ажиллагааны тухай" харилцан ойлголцлын санамж бичиг байгууллаа. Энэхүү харилцан ойлголцлын санамж бичгийг байгуулсанаар хоёр байгууллага эрх тэгш, хамтын ажиллагааны зарчимд тулгуурлан Монгол Улсын агаарын хөлгийн түлшний чанар хяналтын тогтолцоог сайжруулах, техник технологийн дэвшил, боловсон хүчнийг чадавхжуулах, техникийн хамтын ажиллагааг бэхжүүлэх чиглэлээр хоёр улсын нисэхийн салбарын хөгжилд хувь нэмрээ оруулах юм.

"Иргэний нисэхийн үндэсний төв" ТӨХХК, Тайландын хаант улсын "Аэронотикал Радио Тайланд" ХХК-ийн хооронд хамтын ажиллагааны санамж бичгийг 2025.05.24-ний өдөр байгууллаа. Энэхүү санамж бичгийг байгуулсанаар Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-ын Стандарт зөвлөмжийн дагуу агаарын навигацийн үйлчилгээний чиглэлээр "Иргэний нисэхийн үндэсний төв" ТӨХХК болон "Аэротай" хооронд хоёр талын хамтын ажиллагааг хөгжүүлэх явдал бөгөөд хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд хоёр байгууллага ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор хамтарсан хөтөлбөр, сургалт зохион байгуулах болон мэргэжилтэн солилцооны хөтөлбөр хэрэгжүүлж ажиллана.

ДЭЭД ШАТНЫ БАЙГУУЛЛАГУУДААС ӨГСӨН ҮҮРЭГ ЧИГЛЭЛ, ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

- ✓ Зам, тээврийн сайдын 2025 оны 01 дүгээр албан даалгавраас тус төвд хамааралтай 31 арга хэмжээ хэрэгжүүлэхээс 100%-тай 19, 70%-тай 6, хугацаа болоогүй 6 ажил байна. Хэрэгжилт эхний хагас жилийн байдлаар 92,8%-тай байна.
- ✓ ИНЕГ-ын даргын 2025 оны 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтээс "ИНҮТ" ТӨХХК-д хамааралтай 1 заалт 4 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллахаас эхний хагас жилийн байдлаар 100%-ийн хэрэгжилттэй байна.
- ✓ Зам, тээврийн сайдын 2025 оны тушаалын хэрэгжилтийн тус компанид хамааралтай 4 тушаалын хэрэгжилт 100%-тай байна.
- ✓ ЗТЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2021-2025 оны тушаалын хэрэгжилтийг эхний хагас жилийн байдлаар тус компанид хамааралтай 2 тушаалын хэрэгжилт 100%-тай байна.

АЖИЛЧДЫН НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАН АЖИЛЛАСАН ТУХАЙ

Иргэний нисэхийн салбарт 2025-2027 онд хэрэгжүүлэх хамтын гэрээг байгуулсан. Тус хамтын гэрээнд дараах дэвшилттэй заалтууд тусгагдсан. Үүнд:

- Цалин хөлсний зохицуулалтыг илүү нарийвчилж удаан жилийн нэмэгдлийг нисэхийн салбарт ажилласан хугацааг харгалзан тодорхой хувиар нэмэгдүүлэх, мөн мэргэшлийн зэргийн нэмэгдэл, эрдмийн зэргийн нэмэгдэл зэргийг тодорхой шалгуурыг үндэслэн олгох,
- Нийгмийн хамгаалал болон эх хүүхдийн хамгааллын бодлого хэсэгт нэг удаагийн тэтгэмж урамшуулалыг үе шаттайгаар нэмэгдүүлэх,
- Эрүүл мэнд аюулгүй байдлыг хангах чиглэлээр эрсдлийн түвшин их ажлын байрны жагсаалтыг гаргаж амь нас эрүүл мэндийн даатгалд хамруулах зэрэг ажилчдын нийгмийн баталгааг хангах тал дээр илүү нарийвчилсан зохицуулалтыг тусгаж өгсөн.

Ажилчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр:

- ✓ Хүүхэд асрах чөлөө авсан 13 ажилтанд тус бүр 2.000.000 төгрөгийн тэтгэмж;
- ✓ Анх удаа гэр бүл болсон 4 ажилтанд тус бүр 500.000 төгрөгийн дэмжлэг;
- ✓ Өндөр насны тэтгэвэрт гарсан 14 ажилтанд 1-36 сарын дундаж цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмж олгож өндөр настны бүртгэлд бүртгэсэн.
- ✓ Хөдөлмөрийн чадвараа 70 буюу түүнээс дээш хувиар алдсан нь эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэрээр тогтоогдсон 3 ажилтанд 1-36 сарын дундаж цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмж олгож өндөр настны бүртгэлд бүртгэсэн.
- ✓ Нас барсан 5 өндөр настан болон ажилтны ар гэрт тус бүр 1.000.000 төгрөгийн буцалтгүй тусламж;

- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй 11 ажилтанд хүүхдийнх нь эмчилгээний зардалд зориулж тус бүр 1,000,000 төгрөгийн тэтгэмж;
- ✓ 1-3 сарын хугацаагаар өвчилж, хөдөлмөрийн чадвараа түр алдсан 7 ажилтанд эмнэлгийн магадалгааг нь үндэслэн тэтгэмжийг жилд нэг удаа;
- ✓ Орон тоо нь хасагдсан 13 ажилтанд иргэний нисэхийн салбарт ажилласан жилээр тооцон нэг удаагийн тэтгэмж;
- ✓ Ажилтны гэр бүлийн гишүүд (эхнэр, нөхөр, төрсөн болон хадам эцэг эх, үр хүүхэд, ах, эгч, дүү) нас барсан тохиолдолд нас барсны гэрчилгээний хуулбар, ажилтны гаргасан өргөдлийг үндэслэн 1,000,000 төгрөгийн буцалтгүй тусламжийг 21 ажилтанд;
- ✓ Ажилтан өвчнөөр, зуурдаар нас барсан тохиолдолд тухайн ажилтны ажилласан жилээс хамааруулж нийт 3 хууль ёсны өвлөгчид дундаж цалин хөлстэй тэнцэх хэмжээний тэтгэмж, ар гэрт нь 1,000,000 сая төгрөгийн нэг удаагийн тусламж;
- ✓ 2025.05.13-ны өдрийн байдлаар нийт 4 ажилтанд цалингүй хувийн чөлөө, 7 ажилтанд сургалтын чөлөө;
- ✓ "ИНҮТ" ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлын 2025.03.07-ны өдрийн А/107 дугаар тушаалаар Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Мартын 8-ны баярыг тохиолдуулан нийт 865 эмэгтэй ажилтнуудад 100.000 /зуун мянга/ төгрөгийн 86.500.000,0 төгрөгийн гарын бэлэг;
- ✓ Хаврын тэргүүн сарын шинийн нэгэн буюу Цагаан сарын баяраар нийт 766 ахмад настанд 50,000 төгрөг, 80-аас дээш насны 83 ахмад настанд 200,000 төгрөгийн дэмжлэгийг эхний хагас жилийн байдлаар тус тус олгоод байна.

ТАНИЛЦСАН:
"Иргэний нисэхийн үндэсний төв" ТӨХХК-ийн
Захиргаа, санхүү хариуцсан ерөнхий
менежер Н.Золжаргал

"Иргэний нисэхийн үндэсний төв" ТӨХХК-ийн
Захиргаа удирдлагын газрын менежер Д.Ариунтуяа

ХЯНАСАН:
Захиргааны хэлтсийн дарга С.Шижирнаран

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
Захиргааны хэлтсийн салбар,
нэгж хариуцсан мэргэжилтэн Т.Эрдэнэдалай